давхрагын дундаж зузааныг 1.1 м-ээр тогтоожээ. Шинжээч дээрхи нөөцийн тооцоонд хяналтын хэмжилт, тооцоо хийж, алтны бодитой (В) нөөцийг химийн цэврээр 73.3 кг-аар тогтоосон ба нөөцийн блокуудын дунджаар алтны агуулгыг 298 мг/м³, хуулах хөрсний дундаж зузааныг 0.3 м, алт агуулсан элсний давхрагын дундаж зузааныг 1.1 м-ээр тооцоолж, нөөцийн тооцоонд зөрүү бараг гараагүй учир ордын хайгуулын 130-144 дүгээр шугамын хооронд тогтоосон нөөцийг зохиогчийн хувилбараар хүлээн авахыг санал болгосон ба ЭБЗ-ийн хуралдааны үед гишүүдийн олонхийн саналаар алтны нөөцийг шинжээчийн хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх, энэхүү бүртгэлд авсан геологийн нөөц орд газрыг ашиглах явцад батлагдаагүйтэй холбогдож гарсан аливаа асуудлаар ЭБЗ хариуцлага хүлээхгүй ба орд, гүүний аль нэг блокийн нөөцийг ашиглахаар уулын ажлын төлөвлөгөө хийхийн өмнө баттай (А), бодитой (В) нөөц тогтоосон бол ашиглалтын хайгуул, боломжтой (С) нөөц тогтоосон бол гүйцээх болон ашиглалтын хайгуул хийж, ашиглах нөөцөө баталгаажуулах ёстой болохыг лиценз эзэмшигчид анхааруулахыг зүйтэй гэж үзэв.

6. Зохиогчид Баруун Баруун Уртын алтны шороон ордын хайгуулын 130-44 дүгээр шугамын хооронд хийсэн хайгуулын ажлаар тогтоосон шороон алтны нөөцийн тооцоонд хэрэглэсэн ордын жишгийн үзүүлэлтийг ордын урьд талын үргэлжлэлийнхээр адилтган авч хэрэглэсэн байна. Үүнд:

- нөөцийн хил дэх ашигт давхрагын зузааныг тодорхойлох захын хамгийн бага агуулга 80 мг/м³,
- ордын хил заагийг тогтоох малталтын захын агуулга 80 г/м³,
- үйлдвэрийн хамгийн бага агуулга 80 мг/м³,
- ашигт давхрагын хамгийн бага зузаан 0.4 м,
- нөөцийн тооцоонд оруулах алтны агуулгагүй болон жишгийн бус агуулгатай үеийн хамгийн бага зузаан 2.8 м.

Алтны сорьцийг СЭЗЯ-ны Сорьцын улсын хяналтын албаны Үнэт металлын сорьц тогтоох лабораторид 885 гэж тодорхойлжээ.

7. Өмнө нь ГТЛ-д хийлгэсэн элс баяжуулах технологийн туршилтын үр дүнгээс үзэхэд уг ордын хэмжээнд элсэндэх бул чулуу +10 см 2-3%, жижиг, дунд хайрга, хайрганцар, дайрга 40-50%, үлдсэн хэсэг нь элс, супесь эзлэх ба шаварлаг хэсэг маш бага, угаагдах чанараар сайнд ордог, алтны мөхлөг +3 мм-ээс дээш хэмжээтэй 4.55%, 3-2 мм-5.43%, 2-1 мм - 15.35%, 1-0.5 мм-29.55%, 0.5-0.25 мм нь 35.35%, -0.25 мм-9.8%-ийг эзэлдэг ба элсийг скрубер (усан буу), сэгсрэх ширээ ашиглан баяжуулсан нөхцөлд металл авалт 85%-иас дээш байх боломжтой гэж үзжээ.

8. Орд нь цэвдэгшилгүй, хөрсний усжилт муу, алт агуулсан элсний давхаргын сийрэгжилтийн итгэлцүүр 1.4 %, бул чулуу бага. Ордыг ашиглах үеийн ундааны ба техникийн усан хангамжийн асуудлыг гүний худаг өрөмдөх замаар шийдвэрлэх боломжтой гэж үзжээ.

9 Орд газрыг ашиглах ТЭЗ-ийн урьдчилсан тооцоогоор ордыг 5 жилийн хугацаанд ашиглаж дуусгах, энэ тохиолдолд хөрөнгө оруулалтаа эхний 2 жилд нөхөх боломжтой. Ордын хэмжээнд нийт 30.2 мян. м³ хөрс хуулж, 195.7 мян. м³ элс угааж, ашиглалтын технологийн хаягдлыг 8%, ашиглалтын хаягдлыг 15%, бохирдолтыг 3%-иар тооцсоноор химийн цэврээр 64.98 кг алт олборлон борлуулснаар борлуулалтын нийт орлого 812.25 сая төг, ашиглалтын зардал 706.6 сая төг, цэвэр ашиг 37.9 сая төг, 1 г алтны өөрийн өртөг 10 875.0 төг байхаар тооцсон байна.

10. Ордын хайгуул хийсэн хэсгийн геологийн тогтоцыг Б.Алтан-Очирын өмнө нь хайгуул хийсэн түүний үргэлжлэлийнх нь геологийн тогтоцтой адилтган үзэж, тайланд энэ бүлгийг бичээгүй атал энэ тухай ишлэл хийж өгөөгүй, сорьцийн эзэлхүүнийг бага (0.024 м³)-аар авсан нь нөөцийн тооцооны үнэмшлийг хангалтгүй гэж үзэхэд хүргэсэн, өмнөх хайгуулын 130 дугаар шугамаас дээш 10 м-ийн зайтай шугамаар 8 шурф нэвтэрч, сорьцлоход 5 шурфэнд алт гарсан атал түүний үр дүнг ашиглан В-15 блокийн нөөцийг тооцоогүй, ордын геологи, геоморфологийн болон алтны тархалт, ул суурийн зургийг зургийг зохиогоогүй, ТЭЗ-ийн урьдчилсан тооцоог хангалтгүй хийсэн, 1 г алтны өртгийг үндэслэлгүй өндөр авсан байдлыг заан тэмдэглэж, орд газрыг ашиглах ТЭЗҮ боловсруулахын өмнө дээр дурьдсан зүйлийг гүйцээн хийх, технологийн усны судалгаа гүйцэтгэж, орд газрыг ашиглах явцад ашиглалтын хайгуулыг тогтмол хийх замаар эрсдэлээ багасгаж ажиллахыг лиценз эзэмшигчид анхааруулахаар тогтоов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн зөвлөл дараахь заалт бүхий тушаал гаргахыг АМХЭГ-ын даргад уламжлахаар шийдвэрлэв.

1. "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дахь Баруун Баруун Уртын алтны шороон ордын хайгуулын 130-144 дүгээр шугамын хооронд 2003 онд хийсэн гүйцээх хайгуулын ажлын үр дүнгийн тайлан" (Нөөц 2003 оны 12-р сарын 31-ний байдлаар) дахь хайгуулын 130-144 дүгээр шугамын хооронд тогтоосон алтны бодитой (В) нөөцийг химийн цэврээр 73.1 кг-аар хүлээн авах;

2. Хуралдааны энэхүү тэмдэглэлийн дагуу хүлээн авсан алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв (Х.Гантөмөр)-д зөвшөөрөх;

3. Баруун Баруун Уртын алтны шороон ордын хайгуулын 130-144 дүгээр шугамын хооронд тогтоосон алтны бодитой нөөцөд тулгуурлан, түүнийг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзэх;

4. Энэхүү тэмдэглэлийн 10-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг "Хунан"ХХК (С.Цэрмаа)-д анхааруулах;

5. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дисккийн хамт ЭБЗ-ийн хуралдааны энэхүү тэмдэглэл, түүний дагуу гаргасан АМХЭГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн мэдээллийн төвд хүлээлгэн өгөхийг "Хунан"ХХК (С.Цэрмаа)-д даалгах.

ЭРДЭС БАЯЛГИЙН ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ГАНБААТАР

Б.БЭГЗСҮРЭН

ЭБЗ-ийн 2004 оны 6 дугаар сарын
17-ны өдрийн хуралдааны 16 - 01
дугаар тэмдэглэлийн хавсралт

Баруун Баруун Уртын алтны шороон ордын
хайгуулын 130-144 дүгээр шугамын хоорондох
алтны нөөцийн тоолооны нэгдсэн хүснэгт

Сорьц: 885

Нөөц, бло- кийн дугаар	Талбай, мян.м ²	Зузаан,м		Эзэлхүүн, мян. м ³		Алтны дундаж агуулга, мг/м ³	Алтны нөөц, кг	
		Хуулах хөрс	Элс	Хуулах хөрс	Элс		Шли- хээр	Хим. цэврээр
В-15	14.4	0	1.4	0	19.7	494	9.5	8.6
В-16	16.3	0.3	1.5	4.3	25	425	10.6	9.4
В-17	39.9	0.3	1.5	12.5	58.1	358	20.8	18.4
В-18	28.6	0.2	1.5	5.3	42.2	420	17.7	15.7
В-19	14.7	0.2	1.4	2.4	21.2	591	12.5	11.1
В-20	11.1	0.1	0.9	0.7	9.6	537	5.2	4.6
В-21	17.8	0.3	1.1	5.0	19.9	298	5.9	5.3
Нийт: В	143.0	0.2	1.3	30.2	195.7	446	82.5	73.1

Тусгай зөвшөөрөл MV-008097, ТЭЗҮ-ийн дүгнэлт

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар Т/156.

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Т/20-10-14 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-008097 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хунан ХХК-ийн Баруун, Баруун-Уртын (хш-130-144-ийн хооронд) нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (тодотгол)-ийг хүлээн авсанд тооцсугай.


2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

5. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-008097 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баруун, Баруун-Уртын (хш-130-144-ийн хооронд) нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (тодотгол)-ийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Хунан ХХК-д даалгасугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

53701329



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар Т/20-10-14

Улаанбаатар хот

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-008097 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн Баруун, Баруун-Уртын /хш-130-144-ийн хооронд/ алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг хэлэлцсэн тухай

“Хунан” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Бат оюу цэн” ХХК боловсруулсан Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-008097 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн Баруун, Баруун-Уртын /хш-130-144-ийн хооронд/ алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголд уул уурхайн зөвлөх инженер Ц.Жанчив зөвлөж, уул уурхайн зөвлөх инженер З.Төмөрбаатар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь ордын тухай ерөнхий мэдээлэл, ил уурхайн олборлолт, баяжуулалт, уурхайн цахилгаан хангамж, уурхайн дэд бүтэц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт хаалтын төлөвлөлт, эдийн засгийн үр ашгийн тооцоо гэсэн 16 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 93 хуудас тайлбар бичиг, 10 хавсралт зургуудаас бүрдэж байна.

2. Баруун, Баруун-Урт нэртэй MV-008097 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн Баруун, Баруун-Уртын /хш-130-144-ийн хооронд/ алтны шороон ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2004 оны 06 дугаар сарын 17-ний өдрийн хурлын 16-01 тоот дүгнэлтийг үндэслэн АМХЭГ-ын даргын 2004 оны 06 сарын 24-ны өдрийн 75 тоот тушаалаар алтны нөөц нь бодитой (В) зэргээр шлихээр 82.5 кг, химийн цэврээр 73.1 кг-аар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Энэхүү нөөцөөс өмнөх жилүүдэд олборлон тушаасан нөөцийг хасаж үйлдвэрлэлийн VI зэрэглэлээр шлихээр 60.35 кг, химийн цэврээр 53.41 кг нөөцөнд тулгуурлан ТЭЗҮНТ-ыг боловсруулсан байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо бохирдлыг 31.3% (42.2 мян.м3) авч тооцсон ба ордыг 2 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 25.74

00002678

мян.м3 хөрс хуулж, магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 176.9 мян.м3 элс олборлохоор төлөвлөсөн байна.

4. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын элсний давхаргын тогтоц болон байршил, хучаас хөрсний зузаан зэргийг харгалзан үзэж хөрсийг тээвэргүй ашиглалтын системээр экскаватораар ашигласан орон зайд дотоод овоолго хийх, олборлосон элсийг автосамосвалаар тээвэрлэн угаах төхөөрөмж рүү хүргэх буюу авто тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

5. Тус уурхайд одоо ашиглаж байгаа R520LC, R370LC-7 маркийн экскаваторууд, SD-23 маркийн бульдозер, Хятад улсад үйлдэвэрлэсэн ZL-50 маркийн утгуурт ачигч, 25 тн даацтай NORDBENZ маркийн автосамосвалууд зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮНТ-д тусгажээ.

6. Баяжуулах технологи туршилтыг Геологийн төв лабораторид хийж боловсруулсан технологийн туршилтыг үндэслэн технологийн схемийг сонгосон. Энэхүү шороон ордын элс дунд ангилалд байгаа наалдцыг усаар угаан шигшиж ангилсаны дараа алт агуулсан нарийн ширхэгтэй ангиллыг хоригт цоргоор баяжуулан алттай шлихыг ялган авч угаах төхөөрөмжөөс ялгасан шлихын баяжмалыг гүйцээн боловсруулна. Гүйцээн ялгалтыг баяжуулах ширээгээр баяжуулан ялгана.

7. Баяжуулах төхөөрөмжийн цагийн хүчин чадал Д-80 м3 байна. Баяжуулах үйлдвэр 272.5 мян.м3 элс угааж 39.34 кг цэвэр алт авна.

8. Баяжуулах үйлдвэрт Д-80 маркийн элс угаах төхөөрөмж болон СКО-0.5 маркийн баяжуулах ширээ зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийн сонголтын тооцоог хийж гүйцэтгэсэн байна.

9. Уурхайн үйл ажиллагаанд өртөгдсөн талбайг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудыг мөрдлөг болгон эвдэрсэн талбайг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгнө. Нөхөн сэргээлтийн зардлыг тус ажлыг гүйцэтгэх стандарт ажилбаруудын зардлыг тооцох замаар техникийн нөхөн сэргээлтийн зардлыг тооцсон бол биологийн нөхөн сэргээлтийн энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авч тооцоолсон байна. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 320.0 сая төгрөг байгаль орчин хамгаалах, хаалт, нөхөн сэргээлтийн зардалд тусгасан байна.

10. Төсөл хэрэгжүүлэгч компани нь G-150 маркийн зөөврийн цахилгаан үүсгүүрээр уурхайн болон угаан баяжуулах хэсгийн цахилгаан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангахаар тооцсон байна.

11. Хүйтэний голын алтны шороон ордын Бичигт хад хэсгийн нөөцийг ашиглах ил уурхайн төсөл хэрэгжүүлэх нийт хөрөнгө оруулалт компанийн тайлан дахь үлдэгдэл үнийг тооцсон хөрөнгө оруулалтын дүн 1044.41 сая төгрөг байна. Үүнээс ил уурхай, угаан баяжуулах хэсгийн хөрөнгө оруулалт 933.41 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 111.0 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. ЭХШ-ийн зардалд жилд 189.1 сая.төг байхаар тооцоолсон байна.

12. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 1209.5 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд цаг хугацааны хүчин зүйлийн итгэлцүүрийг (NPV) 10%-иар авахад төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ нь 827.0 сая төгрөг болж байгаа

ба хөрөнгө оруулалтын өгөөжийн дотоод норм 70% гарсан нь төсөл эдийн засгийн хувьд үр ашигтайгаар хэрэгжих боломжтой гэж үзжээ.

13. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл, байгалийн нөөц ашигласны төлбөр, газар, ус ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад татвар хураамжийг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоол, дүрэм журмын дагуу тооцоолсон байна.

14. Төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт ашиглалтын нийт хугацаанд 1014.47 сая төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх ба төслийн хүрээнд 76 хүн уурхайд ажиллахаар байна. Уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1691.3 мян.төг байхаар тооцсон байна.

15. Ашиглалтын хугацаанд нийт 5.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 4.5 тэрбум төгрөгийн зардал гаргана. Уурхайн ашиглалтын хугацаанд 1 кг алтны бүрэн өөрийн өртөг 102.2 сая.төг/кг байна.

16. Төсөлд шаардлагатай мэргэжлээр орон нутгийн иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

17. Техник-эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

18. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

19. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Бат оюу цэн” ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын зөвлөх инженер З.Төмөрбаатар хариуцах.

20. Техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

21. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс

баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн “Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-008097 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баруун,Баруун-Уртын /хш-130-144 хооронд/ алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотгол”-ыг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.БОЛД-ЭРДЭНЭ

11. БОМТ-ний биелэлтийн тайлан хүлээн авах хяналтын хуудас

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн
А/618 тоот тушаалын хавсралт Журмын 6 дугаар хавсралт
Хүснэгт №1

Хянасан огноо	Шинжээч бөглөнө
Хянасан мэргэжилтний хувийн дугаар	
Дүгнэлт	
Шийдвэрийн төсөл	
Ололт, амжилттай тал	
Дутагдалтай сул тал	
Шаардлага	

Хоёр. Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгодог тугай зөвшөөрөл, дүгнэлт, лавлагааны
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

хүснэгт.№2

д/д	Мэдээллийн төрөл	Утга		
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ дугаар хүчинтэй хугацаа талбай	Ашигт малтмал ашиглах MV-8097 30 жил 77.48		
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ дугаар хүчинтэй хугацаа	хамаарахгүй		
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	хамаарахгүй		
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	2024 онд гаргуулна.		
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2020-10-07 13/6780 БОАЖЯ-ны шинжээч Д.Батмөнх		
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2021 БОАЖЯ-ны ерөнхий шинжээч Ч.Батсансар		
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2023		
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2023		
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах			
	10.Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/ Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн	4.0
			төлөвлөгөөт онд гүйцэтгэх	4.88
		тайлант онд гүйцэтгэсэн	2.8	
		төлөвлөгөөт онд гүйцэтгэх	4.88	
11. ТХГН-ийн тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах		Лавлагаа гаргуусан		

Мэдээллийг гаргасан: С.Ганбат Уул уурхайн инженер. /С.Ганбат/

Тав. Мета мэдээлэл

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

хүснэгт №3

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл 1. Тосгон 2. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт) 3. Хог хаягдлын цэгийн байршил 4. Хог хаягдлын агуулахын байршил 5. Хог хаягдлын далан 6. Химийн бодисын агуулахын байршил 7. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 8. Тухайн жилд хуулах хөрс 9. Гадаад, дотоод овоолго 10. Техникийн нөхөн сэргээлтийн талбай 11. Биологийн нөхөн сэргээлтийн талбай 12. Гүний худгийн байршил 13. Дүйцүүлэн хамгааллын байршил	

Мэдээллийг гаргасан:

202... он сар..... өдөр

Зургаа. Тухайн жилийн арга хэмжээнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээний хяналтын хуудас

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд “тодорхойлсон (+)”, “тодорхойлоогүй (-)” “хамааралгүй (=)” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

хүснэгт №4

Нөлөөллийн ангилал	А.	Б.	В.	Г.	Дүгнэлт
	Тооцсон эсэх	Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	+ + +	+ + +	+ + +	+ + +	
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	+ +	+ +	+ +	+ +	
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг бууруулах	+ + + +	+ + + +	+ + + +	+ + + +	
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	+ +	+ +	+ +	+ +	

Тайлбар: Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэгээний тайлангаас авав.

Мэдээллийг гаргасан: *С.Ганбат* Уул уурхайн инженер. /*С.Ганбат*/

Долоо. Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дүн шинжилгээний хяналт
 - Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
 - Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.

хүснэгт №37

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А.	Б.	В.	Г.
	Тоо	Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Дүгнэлт
7.1.Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ		тийм	тийм	
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
7.3.Нөхөн сэргээлтийн арга хэмжээ - техникийн / га, - м ³ / - биологийн /га/	4.88 га	тийм	тийм	
7.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	-	тийм	тийм	
7.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	1	тийм	тийм	
7.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ		үгүй	үгүй	
7.7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ		тийм	тийм	

Мэдээллийг гаргасан: *С.Ганбат* Уул уурхайн инженер. /*С.Ганбат*/

12. Байгууллагын хариуцлагын даатгалын хуулбар

Энэ асуудлын хүрээнд гэрээг даатгалын компани дээр судалж хийх гэж байна.

13. Нөөц ашигласны төлбөр тушаасан баримтын хуулбар

Оны эцсийн тайлангаар баталгаажиг гарна.

14. Нөөцийн хөдөлгөөний тайлангийн хуулбар

Оны эцсийн тайлангаар баталгаажиг гарна.

15. Хилээр экспортод гаргасан бүтээгдэхүүний талаар гаалийн албанаас гаргасан мэдээ
Манай компани экспортод бүтээгдэхүүн гаргадаггүй.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

2022 оны 5-р сарын 4-ны өдөр

Гаалийн Ерөнхий газрын даргын 2019 оны
А/... дугаар тушаалын ...-р хавсралт

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГААЛИЙН МЭДҮҮЛГЭЭР БҮРДҮҮЛЭЛТ ХИЙСЭН БАРААНЫ
ЛАВЛАГАА (ААН)

ААН	Хунан ХХК
Регистрийн дугаар	2549204
Хаяг байршил	Төв, Сэргэлэн, null, null
Хамаарагдах огноо	2021-12-01 / 2021-12-31
Төрөл	Экспорт
Бүрдүүлэлт хийсэн тоо	0
Гаалийн татвар /төгрөг/	0,00
Онцгой албан татвар /төгрөг/	0,00
Албан татвар /төгрөг/	0,00
НӨАТ /төгрөг/	0,00
Бусад татвар, хураамж /төгрөг/	0,00



Тодорхойлолтын хүчинтэй хугацаа: 2022/06/18 (45 хоног)

Энэхүү тодорхойлолт дах мэдээллийн үнэн зөв эсэхийг <https://gaali.mn/> холбоосоор эрх бүхий этгээд нэвтрэн орж шалгах боломжтой.

16. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000185385

2005.11.07 <i>/ Бүртгэсэн он, сар, өдөр /</i>		1411001082 <i>/ Хувийн хэргийн дугаар /</i>
		2549204 <i>/ Регистрийн дугаар /</i>
Хунан		Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>		
Дүрэм <i>/ Үүсгэн байгуулах баримт бичиг /</i>		
Тушаал <i>/ шийдвэрийн нэр /</i>	01 <i>/ дугаар /</i>	1998.03.09 <i>/ он, сар, өдөр /</i>
4772 7490 9602 4721 0899 <i>/ Код /</i>	Эм, гоо сайхны барааны жижиглэн худалдаа <i>-/</i> Ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт <i>/2002.01.01-/</i> Үсчин, гоо сайхны үйлчилгээ Гадаад дотоод худалдаа Ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа <i>/2007.01.25-/</i> <i>/ Үйл ажиллагааны чиглэл /</i>	
Хугацаагүй <i>/ хугацаа /</i>	1 <i>/ гишүүдийн тоо /</i>	49,352.50 <i>/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
Төв, Сэргэлэн, 1-р баг, Баянбүрд, 1, Утас1: 96667722, Утас2: 98004141, Факс: <i>-/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /</i>		
		
Улсын бүртгэлийн ерөнхий газар Төв аймгийн улсын бүртгэлийн хэлтэс <i>/ Бүртгэсэн байгууллагын нэр /</i> 3058467 4116129088		
<i>Гэрчилгээ дахин олгосон 2020-он 08 сар 14 өдөр</i>		

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Хорлоо овогтой Батэрдэнэ-а Захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2016.08.30	
2	Дахин гэрчилгээ олгов.	2020.08.14	

Эгэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бүх хувийнгүй.



17. “Баруун баруун урт” алтны ил уурхайн 2023 оны үйл ажиллагаа, БО-ны нөхөн сэргээлтийн тайлан Хавсралт зураг №1 масштаб 1:2000

Хавсралт зургийг хавсаргав.